

ТҮВШИНШИРЭЭ СУМЫН 2023 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ

ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн Засаг даргын 2023 оны А/161 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2023” захирамжийн хүрээнд сумын ХАБЭА-н салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, сарын аяны хугацаанд 11 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүүхэд зодож шийтгэхийн эсрэг олон улсын өдөр, олон улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтаж зохион байгуулагдаж байгаа “Миний хүүхэд – Монголын ирээдүй” аяны нээлтийг 4 дүгээр сарын 4-нд хамтарсан баг болон “Үжин” төвийг үүсгэн байгуулагч, сургагч багш Д.Ундраатай хамтран зохион байгуулав. Монголын хүний эрхийн үндэсний зөвлөлийн гишүүн, хүүхдийн эрхийн үндэсний комиссын гишүүн, Хүүхэд, гэр бүл, эмэгтэйчүүдийг гэмт хэрэг хүчирхийллээс сэргийлэх хамгаалах Үжин төвийн үүсгэн байгуулагч Д.Ундраа суманд ажиллаж сумын иргэд, сургуулийн сурагчдад “Миний хүүхэд монголын ирээдүй” аяны хүрээнд сургалт үйл ажиллагаа зохион байгууллаа. Сургалтаар 312 сурагчид болон төрийн албан хаагч, эцэг эхчүүд нийт 391 насанд хүрэгчдэд сургалт зохион байгуулж, хамтарсан багийн үйл ажиллагаа, тайлан төлөвлөгөөтэй танилцаж зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой нэг кейс дээр ажиллаж НАМС программд шивж оруулан урамшуулал авсан.

Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолын дагуу “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, үзүүлсэн тусламж дэмжлэг үзүүлэх журам”-ын хэрэгжилтийн мэдээг 4 сарын 20-нд аймгийн ГБХЗХГазарт хүргүүлсэн.

4 дүгээр сард E-mongolia оператороос 2 иргэн лавлагаа мэдээлэл авсан байна. Сумын вэб хуудсанд цаг үеийн болон сарын ажлын мэдээ, нийт 1 удаа мэдээлэл оруулсан.

2023 оны 04 дүгээр сарын байдлаар сумын нийт суурин хүн ам 3474, өрх 1004, хүн ам, өрхийн мэдээллийн цахим санд хяналт тавьж ажиллаж байна. Шинээр төрсөн 24, нас барсан 3 хүн бүртгэгдсэн.

Долоо хоног бүрийн Даваа гарагт хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг программд тогтмол оруулж байна.

Энэ сарын байдлаар ХХС-гийн нийт 15 зээлдэгч байгаа ба хугацаа хэтэрсэн чанаргүй 6 зээлдэгч, хэвийн 9 зээлдэгч байна. Нийт 152,055,396 төгрөгийн үлдэгдэлтэй байна. 1 зээлдэгч зээл хаасан. Бусад хугацаа хэтэрсэн зээлдэгч рүү холбоо барьж хурдан төлүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сар бүрийн 8-ны дотор байгууллагуудын сарын төсөв гүйцэтгэл, орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл, ОНХСангийн төлөвлөгөө гүйцэтгэл бусад мэдээ мэдээллийг шилэн дансанд шивж байна.

Нийгмийн даатгалын НД 8, НД7 /ажиллагсдын цалин тооцооны хуудас/ тайлангууд мөн татварын ТТ 11, ТТ 12 буюу үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутган тооцсон татварын тайлангуудыг гарган интернетэд шивэн цахимаар илгээсэн. Орон нутгийн ерөнхий орлого, татварын орлогын гүйцэтгэлийн мэдээг шилэн дансанд шивсэн. Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг гаргаж Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. Төсөвт байгууллагуудын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2023 оны төсвийн хуваарийг шилэн дансанд шивсэн.

2024 оны ОНХСангийн хөрөнгөөр суманд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг системд шивсэн.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн олголт, төлөлтийн судалгааг бөглөж аймгийн төрийн сан руу илгээсэн.

Өмчийн газарт ТӨХ маягтуудын дагуу тайланг баталгаажуулсан.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ, БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сумын ОНХС-гийн хөрөнгөөр 2023 онд хийгдэхээр төлөвлөгдсөн ажлуудаас энэ сард “Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл”- 71,0 сая төгрөгийн ажлын худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, 1 компани худалдан авах ажиллагаанд материал ирүүлснийг шаардлагад нийцсэн оролцогч гэж үнэлж, гэрээ байгуулах эрх олгоод байна. Мөн “Трактор худалдан авах”, “Соёлын төвийн ЛЕД дэлгэц худалдан авах ажлуудын тендер зарлагдаж, шалгарсан оролцод гэрээ байгуулах эрх олгогдоод байна.

Багийн дарга нар, хөдөө аж ахуйн мэргэжилтэнтэй хамтран сэг зэмийн устгал хийх газар нутгийн маршрутыг тус сумын нэрийн газрын зурагт гарган тус маршрутын дагуу сэг зэмийн устгалыг хийсэн ба бод 256, бог 1560, нийт 1816 малын сэг зэм устгаад байна.

Сумын нэгдсэн хогийн цэгийн тархалт ихсэж нийт хог тархсан талбай 14 га /8 га-үндсэн талбай/ газарт хүрээд байсан ба 03 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн өнөөдрийг хүртэл хогний машин, ковшоор түрэлт, ачилт хийж 6 га газрын талбайн хогийг цэвэрлэн ухсан нүхэнд булж ариутган халдваргүйжүүлээд байна. Нийт 226 түрэлт, ачилт хийсэн ба 445 литр түлш буюу 1,800,000₮ зарцуулсан.

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын нийтийг хамарсан ажлын хүрээнд “ Сэг зэм устгал ” 20 иргэн, “ Хог хаягдал ” 10 иргэн, “ Ногоон байгууламж ” 20 иргэнийг хамруулахаар төсөл бичиж хүргүүлэн Сэг зэм устгал- хог хаягдал, Ногоон байгууламж төслүүд дэмжигдэж ажиллах хүчний бүртгэлийн ажил хийгдэж байна.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 11 дүгээр хуралдаанд Үнэгт багийн Майханы хяр, Өгөөмөр багийн Лагт орчмын газар нутгийг тусгай хэрэгцээнд авах санал оруулан дэмжигдэж нийт 74615,05 га газар нутгийг бэлчээрийн нөөц газрын ангиллаар орон нутгийн тусгай хэрэгцээнд 15 жилээр авах ИТХ-ын 2023 оны 4-р сарын 03 өдрийн №01 тоот тогтоолыг аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүлэв.

Өгөөмөр багийн нутаг Лагт хэмээх газарт Баяндэлгэр сумаас гүн өрмийн худаг гаргах гэж байгаатай холбогдуулан сумын Засаг дарга, багийн Засаг дарга, газрын даамал, иргэний төлөөллийн хамт очиж тухайн сумын удирдлагуудтай уулзан хилийн цэсийн маргаан шийдвэрлэгдтэл өрмийн ажил хийхгүй байх шийдэлд хүрсэн.

Тэрбум мод тарих хөдөлгөөний хүрээнд 2023 онд таригдах мод болон хийгдэх ажлын төлөвлөгөөг гарган аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүллээ. Аяны хүрээнд 7000 мод тарих, хашаажуулах ажил хийгдэнэ.

Сумын хогийн цэгийг цэгцлэх ажлын хүрээнд хяналт тавих ажлыг 4 удаа хийсэн. Мөн Сэргэлэн багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан эзэнгүй хог хаягдал болон сэг зэмийн тандалтыг Засаг даргын орлогч, байгаль хамгаалагч нарын хамтаар хийж 15 л шатахуун зарцуулсан байна.

Хог хаягдлын хураамжаа төлье аяныг ЗДТГазраас эхлэн зохион байгуулж аж ахуй нэгж, байгууллагуудаар аялан явж байна.

АДАПТ төслийн хүрээнд уст цэгийн хайгуулын судалгааг 4 багийн 6 газарт хийлгэсэн.

Сумын хэмжээнд мал төллөлт 56% тай байна. Үүнд: Ингэ 101, Гүү 197, Үнээ 965, Хонь 66476, ямаа 37046 төллөсөн байна. Төлийн хорогдол 5 унага , 3924 хурга, 1873 ишиг хорогдсон байна.

Том малын зүй бусын хорогдол сумын хэмжээнд 15156 байна. Үүнийг бог бодоор ялган үзвэл 2036 бод, 13120 бог хорогдоод байна. Сумын хэмжээнд нийт малын 3,6% нь хорогдоод байна. Том малын зүй бус хорогдлын мэдээ (ХАА 2), хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн мэдээ (ХАА 3)-г, аж ахуйн бүтээгдэхүүний үнийн мэдээ (ХАА 10)- г хугацаанд нь статистикийн программд шивж орууллаа.

4 дүгээр сарын 14-нд улсын нөөцөөс татан төвлөрүүлсэн нөөцийн 995 ширхэг өвс, 650 ширхэг хивэг, 100 ширхэг долооцыг малчдад хямдралтай үнээр олгож сумын нөөцийн өвс тэжээл дууссан.

Энэ сард “Шавхагдашгүй баялаг” ХХК үржлийн нэгжээр бог малд үзлэг ангилалт хийлгэлээ. Хаврын ээлжит үзлэг ангилалтаар 300 бол малыг үзлэг ангилалтад хамруулж, ээмэгжүүллээ. Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд ээмэгжүүлсэн малаа шивж оруулахаар ажиллаж байна. Үзлэг ангилалтын гэрээг үржлийн нэгжтэй байгуулан, зардлыг сумын ОНХС-гаас гаргасан. Мөн энэ онд шаардагдах 1000 ширхэг бог малын ээмэгний захиалгыг “Тэргүүн сүрэг” ХХК-д хүргүүлж, гэрээ байгуулсан.

Эрчимжсэн мал аж ахуйн судалгааг хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн. Суманд эрчимжсэн аж ахуй эрхэлдэг 1 өрхөд симменталь үүлдрийн 14 тооны үхэр байна.

Орон нутгийн өвчний 8 төрлийн вакциныг аймгийн Мал эмнэлгийн газраас татан авч, аж ахуй нэгжүүддээ хуваарилан өгсөн. Мал эмнэлгийн нэгдсэн системд тухайн 8 төрлийн дархлаажуулалтын төлөвлөгөөг оруулсан. Мөн аж ахуй нэгжийн эмч тасгийн эмч нартай хамт МЭЕГ, аймгийн МЭГазартай хамтран зохион байгуулсан хурал, зөвөлгөөнд бүрэн хамрагдсан. Гоц халдварт / A010/ Шүлхий өвчний дархлаажуулалт эхлэх гэж байгаатай холбогдуулан сумын нийт үхэр сүрэгт хийгдэх дархлаажуулалтыг аймгийн Мал эмнэлгийн газраас татан авч аж ахуй нэгжүүддээ хуваарилаад байна. Мөн цахим системд төлөвлөлтийг оруулж ажиллалаа. Мөн долоо хоног болгон сэг, зэм, ариутгал халдваргүйтгэлийн мэдээг өгч ажиллаж байна. Гоц халдварт шүлхий өвчний ийлдэс судлалын тандалт хийх удирдамжийн дагуу аж ахуй нэгжийн 1 эмч, тасгийн 2 эмч нийт 3 хүний бүрэлдэхүүнтэй уг ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд сонгогдон ирсэн 3 айлын хонь 18, ямаа 18, үхэр 12 нийт 48 толгой малаас цус авч ийлдэсийг ялган аймгийн Мал эмнэлгийн лабораторит хүргүүлсэн.

НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

НИЙГМИЙН ХАЛАМЖ: 04 дүгээр сард 2020-2022 онд төсөл хөтөлбөрт хамрагдсан 21 иргэнээс хуваарийн дагуу 13090550 мян.төгрөг төвлөрүүлэхээс 20 иргэн 12040,0 мян.төгрөгийг ХЭДСанд төвлөрүүлсэн.

ХЭДС-аас олгогдох “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа”-4 иргэн, “Иргэн, аж ахуй эрхлэгчдэд олгох санхүүгийн дэмжлэг”-2 иргэн, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ”-2, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг”-т 4, нийт 12 төслийг хугацаанд нь хүлээн авч, үнэлгээг хийсэн.

МУЗГазрын 2023 оны “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам” батлагдсантай холбогдуулан 5 иргэнд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаарх мэдээллийг е-халамж программаар дамжуулан өгсөн.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд хамрагдсан 4 иргэнийг 354690 төгрөгийн нөхөн олговорт хамрууллаа.

Энэ сард сумын амьжиргаа дэмжих зөвлөл 1 удаа хуралдаж 5 иргэнийг нийгмийн халамжийн асаргааны тэтгэмжид хамруулсан. Мөн энэ сард нийгмийн халамжийн е-халамж системд нийгмийн халамжийн тэтгэвэр сунгалт-1 иргэн, цалинтай ээж хөтөлбөрийн тэтгэмжид-6 иргэн, жирэмсэн эхийн тэтгэмжид- 7 иргэн, нийт 14 иргэний мэдээллийг бүртгэсэн.

НИЙГМИЙН ДААТГАЛ: Эрүүл мэндийн даатгалд 19 хүний 1683500 төгрөг , сайн дурын даатгалд 43 хүний 6388197 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 6 төсөвт байгууллагын 7530812.80 төгрөгийн орлого орсон. 4 дүгээр сарын тэтгэвэрт 2 банкаар дамжуулан 425 хүнд 206500053 сая төгрөгийн тэтгэвэр олгосон. Шинээр 2 иргэний тэтгэврийн материал хүлээн авч, тэтгэвэр тогтоогдсон. 3 хүнд 8083584 төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж олгосон. 3 хүнд 6302647 төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж олгогдсон.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР: ЕБС: Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан Хүүхдийн спортын анхдугаар наадамд сургуулийн волейболын тамирчид 3-р байр эзэлсэн амжилтыг гаргалаа.

Японы Киото их сургуулийн төгсөгч, Сүхбаатар аймгийн Математикийн хичээлээр ЭШалгалтын хамгийн анхны 800 оноо авсан оюутан Б.Долгормаа ахлах ангийн сурагчдад “Хичээл, зүтгэл, амжилт” ярилцлагыг зохион байгууллаа. Хүүхдүүд ирээдүйн мэргэжлээ хэрхэн сонгох, шалгалтад хэрхэн амжилттай бэлтгэх гэх зэрэг сонирхсон асуудлаараа нээлттэй ярилцлага зохион байгууллаа.

9 дүгээр ангийн сурагчид суурь боловсролоо эзэмших, улсын шалгалт өгөхтэй холбоотойгоор тухайн ангид хичээл ордог мэргэжлийн багш нарын хурлыг зохион байгуулж 9 дүгээр ангийн сурагчдыг байлцуулан цаашид юунд анхаарах, улсын шалгалтад хэрхэн амжилттай бэлтгэх, дэвтэр номын ашиглалт сэдвүүдээр ярилцлаа.

Улсын төрөлжсөн олимпиадын 2-ын даваа Монгол хэл бичгийн МАСС олимпиад улсын хэмжээнд зохион байгуулагдаж 9б ангийн сурагчид оролцож 3-р байр эзэлсэн амжилт үзүүллээ.

Мэргэжлийн багш нар судлагдахуун бүрээрээ заадаг анги бүрээс түвшин тогтоох шалгалт авч материалыг засалт хийж анализ дүгнэлтийг гаргав. Энэхүү шалгалт нь 5 дугаар сард зохион байгуулагдах Багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд бэлтгэх, мэдлэг чадварыг бататгах зорилготой үйл ажиллагаа байлаа.

12 дугаар ангиа төгсөж байгаа сурагчдын Монгол хэл бичгийн эрхийн шалгалтад 12-р ангийн 21 суралцагч, Анги удирдсан багш Монгол хэл бичгийн багш, Сургалтын менежер нар Сүхбаатар аймгийн 1 дүгээр бүрэн дунд сургуульд хамрагдлаа.

5 дугаар ангийн сурагчдын дунд монгол хэлний хичээлээр зохион байгуулагдсан “Эрэл” хүүхдийн жүжгээр дүрийн тоглолтод 7 баг оролцлоо.

Өдөр бүр нээлттэй хичээл заах уралдаанд 17 залуу багш нар амжилттай оролцлоо.

“Зан төрх танин мэдэхүйн бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжих арга зүй” онлайн сургалтанд бага ангийн 5 багш хамрагдаж батламж авсан.

"Дотуур байр ээлтэй орчин" аяны хүрээнд дотуур байр болон анги удирдсан багш нарын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор "Өдөр бүр нэг багш" үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж байна.

Итали улсын хөрөнгө оруулалттай ASIA MONGOLIA” ТББ-аас хэрэгжүүлж буй “Орон нутгаас Дэлхий рүү” төслийн хүрээнд сургуулиудын клубүүдын үйл ажиллагааг сайжруулах, дэмжих зорилгоор зохион байгуулсан Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн “CODING STUDY CLUB ”-ын 2 дахь удаагийн нээлттэй өдөрлөгийг зохион байгууллаа.

“Бүтээлч багш-шилдэг арга зүй” STEM сургалтын ур чадварын уралдааны 1 дүгээр шатанд бага ангийн багш нар оролцож багш М.Ариунсүвд 80.6 хувийн гүйцэтгэлээр тэргүүн байр эзэлж 2-р шатанд оролцох эрхтэй боллоо.

ЦЭЦЭРЛЭГ: Байгууллага болон бүлэг бүр ариутгал, цэвэрлэгээг тогтмол хийж, кварцийн гэрлээр ариутгаж байна. Мөн байгууллагын гадна, дотно орчмын цэвэрлэгээг хийж, цэвэр орчинг бүрдүүлэн ажиллаж байна.

Аймаг орон нутгийн үндсэн болон залуу багшийн сургалтад 6 багш, ажлын байрны 4 сургалт, цахим 5 сургалтад тус тус хамрагдсан байна.

“Энэ жилдээ-Эрүүл жиндээ” аяны хүрээнд өглөө бүр байгууллага дээрээ дасгал хөдөлгөөн хийж хэвшээд байна. Мөн ЭМТ-өөс зарласан “Цаг гаргая” аяны хүрээнд бямба гарагийн өглөө гүйж, дасгал хөдөлгөөн хийж, витаминжуулсан.

ХАБ-ын сарын аяны хүрээнд “Шар дарцаг” аянг өрнүүлж бүлэг бүрийн эцэг эхчүүд хүүхэд хүлээн авах, тарах үеэр эргүүл хяналт тавьж зохицуулалт хийн ажиллаж байна. Мөн “Ачит шүд” аяны хүрээнд 8 бүлгийн хүүхдүүдийг шүдний үзлэгт хамруулсан. Туслах багш нарын дунд “Аюулгүй амьдрах ухаан” сэдэвт сайн хичээл үйл ажиллагааг зохион байгуулсан.

Бүлгийн багш нарын дунд САЙН ХИЧЭЭЛ ур чадварын уралдааныг зохион байгуулсан.

Сумын соёлын төвтэй хамтран ахлах, бэлтгэл бүлгийн дунд үлгэрийн номыг аялуулж, үлгэрийн тухай ярилцаж, үлгэрийн баяжилт хийсэн.

Байгууллага болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах БЕГ-ын өгсөн үүрэг чиглэлийн дагуу ажиллаж Эрхлэгчийн 2023 оны 04 сарын 14 ны өдрийн

A/01 тоот тушаалаар үнэлгээний багийг Арга зүйчээр ахлуулсан 6 бүлгийн багш, 2 эцэг эхийн төлөөлөлийг оролцуулан байгуулж, нууцлалын баталгааны хуудсыг танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулсан. Үнэлгээнд тус байгууллагын бүлгийн багш-7, ХЭМ-ийн багш-1 тус тус хамрагдахаар бүртгэлд орж 100% хамрагдсан. Өдрийн бүлэгт хамрагдаж буй 257 хүүхдээс 111 хүүхэд нь багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд түүвэрлэгдэн сонгогдож 100% хамрагдсан.

СОЁЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Соёлын төвийн дэргэдэх нийтийн номын сан нь энэ сард 36 хүүхэд, 10 насанд хүрэгчдэд ном олгох үйлчилгээг үзүүлж ажилласан.

Аймгийн Нийтийн номын сангийн захирал, арга зүйч нар ирж номын сангийн үйл ажиллагаатай танилцаж зөвлөн туслаж Судар эгшиглэн төслийн хүрээнд 1-5-р ангийн хүүхдүүдтэй уулзалт сургалтыг зохион байгуулж танин мэдэхүйн АХА тэмцээнийг хамтран зохион байгуулсан.

Соёлын төвийн дэргэдэх “Шидэт бийр” зургийн дугуйлантай хамтран “Үлгэрийн ертөнцөөр аялцаа” сэдвийн дор, урлагийн сурагчдыг номтой нөхөрүүлж байна.

ЕБС-ийн дотуур байрын сурагчдын дунд “Дэлхийн номын өдрийг угтан” “Хамтдаа уншья-Хамтдаа бүтээ” сэдэвт нутгийн зохиолчдын бүтээлээр Мэндчилгээ, Дүрийн тоглолт, Асуулт хариулт гэсэн 3 үе шаттай багийн тэмцээн зохион байгуулж 8 багийн 94 хүүхэд оролцлоо.

СӨБ-тай хамтран “Үлгэрч өвөө эмээ” тэмцээнийг зохион байгуулж 19 ахмадууд оролцсон.

Түүх Соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалагчдыг шинэчлэн бүртгэж, сүм хийд иргэдийн гар дээрх баримтат өвийн судалгаануудыг нэгтгэн СУГ-т хүргүүлсэн. Цахим орчинд монгол тоглоом наадгайн мэдээллийг 4 удаа нийтэлсэн.

Соёлын өв болох Түвшинширээ сумын Үндэсний шагай харваа тэмцээнийг СӨБ, Сумын шагай харвааны баг хамт олонтой хамтран 4 аймгийн 112 харваачид оролцлоо. Энэ сард 9-н төрлийн дугуйлан цагийн хуваарийн дагуу 108 хүүхдийг хамруулан хичээллэж байна.

“Шидэт бийр” зургийн дугуйлангийн 1жилийн ойг тохиолдуулан “Гэрэлт зам-2” үзэсгэлэнг Түвшинширээ нутгийн ард иргэд хүүхэд багачууддаа дэлгэлээ.Нээлтийн үйл ажиллагаа үзэсгэлэнд 391 иргэн хамрагдсан.

ЕБС-ын 6-12 ангийн хүүхэд багачуудад 7 хонгийн 2 өдөр 16 тоот, заавал сурах стандарт 10 бүжгээс зааж сургаж байна. Мөн ахмадуудынхаа дунд 7 хонгийн 3 дах өдрийн 14:30-аас 17:00 цаг хүртэл цэнгүүний үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Энэ сард СТА Д.Бердибекийн “Чин зүрх”, Т.Эрдэнэбаярын “Ааваа зорино”, Жаахан шарга театрын “100 тоот өрөө” жүжиг, тоглолтууд, мөн нийтийн цэнгээнт бүжгүүдийг зохион байгуулж ажиллалаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР: Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторийн нийт үзлэг 163, алсын дуудлага 17, гэрийн дуудлага 5, хэвтэн эмчлүүлэгч 26, хэвтэн эмчлүүлэгч Ковид /Халдвартай бүс/ - хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөн байхгүй.

Эрүүл мэндийн төвийн гадна болон дотор талд бүх ажилчдыг хамарсан их цэвэрлэгээг 2 өдрийн турш зохион байгууллаа.

Мөн Ёс зүйн багаас эрүүл мэндийн төвийн ажилчдад төрийн албан хаагчийн болон эмнэллгийн ажилтны ёс зүйн талаар сургалт зохион байгуулж, албан хаагчдын дунд “Хөдөлгөөн эрүүл мэнд” сэдэвт гар бөмбөг, бухиа, Сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулсан.

“Энэ жилдээ-Эрүүл жиндээ” аяны хүрээнд албан байгууллага аж ахуй нэгж байгууллагатай хамтран өглөөний дасгал, гүйлтийг зохион байгуулж хэвшээд байна.

Энэ сард сар бүр хийгддэг товлолын вакцинд нийт 60 хүүхэд хамрагдсан байна.

Тухайн сард Лабораторын хийсэн шинжилгээ үйлчилгээ: сахар – 13, үе мөч – 12, шээсний ерөнхий шинжилгээ – 30, элгэний В, С вирус– 3, БЗХӨ - 4 шинжилгээ тус тус хийгдсэн байна.

Тайлан нэгтгэсэн:

ХЭЗМэргэжилтэн

Ш.Дүүрэнбилэг

Хянасан:

Тамгын газрын дарга

Ц.Ренчинмядаг